Оны эхэнд ЗДТГ 207.9 мянга, сум хөгжүүлэх сан 153062.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байсан ба тайлант хугацаанд Засаг даргын Тамгын газар авлагыг барагдуулж, Ерөнхий боловсролын сургууль 9950.0 мянган төгрөгийн ухаалаг самбарын үнийг шилжүүлж орлого аваагүй, Соёлын төв 119.9 мянган төгрөгийн байгууллагаас авах авлага, сум хөгжүүлэх сан 44280.9 мянган төгрөгийн авлага шинээр үүссэн байна.

Хүснэгт № 3. Авлагын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засаг даргын Тамгын газар	207.9	0	-207.9	
Ерөнхий боловсролын сургууль		9950.0	9950.0	4.8
Сум хөгжүүлэх сан	153062.0	197342.9	44280.9	95.1
Соёлын төв		119.9	119.9	0.1
НИЙТ ДҮН	153269.9	207412.9	54142.9	100

Эх сурвалж: Баянцагаан сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын насжилтаар нь авч үзвэл Ерөнхий боловсролын сургууль, соёлын төвийн авлагууд тайлант онд үүссэн, сум хөгжүүлэх сангийн авлага 1-3 жилийн насжилттай 194574.1 мянга, 4 жилийн насжилттай 1044.0 мянга, 2013 онд зээл авсан 7 жилийн насжилттай 1724.8 төгрөгийн авлага байна. Дээрх 1724.8 мянган төгрөгийн авлагыг шүүхэд шилжүүлж шүүгчийн шийдвэр гарч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд шилжсэн байна.

3.5.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 209790.9 мянга, эцсийн үлдэгдэл 218756.1 төгрөг болж, 8965.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 4. Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	46327.9	49810.1	3482.2
Бичиг хэргийн материал	2134.8	2649.3	514.5
Аж ахуйн материал	45093.6	64914.0	19820.4
Түлш, шатах тослох материал	165.0	501.0	336.0
Барилгын засварын материал	850.0	2677.2	1827.2
Бусад хангамжийн материал	27304.6	35810.9	1827.2
Мал амьтад	35915.1	12382.4	8506.3
Эм боох материал		5011.2	5011.2
Дуусаагүй үйлдвэрлэл	52000.0	45000.0	-7000.0
Дүн	209790.9	218756.1	8965.2

Эх сурвалж: Баянцагаан сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Энэ нь Ковид-19 цар тахалтай холбоотой төсвийн хөрөнгөөр эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авсан нь үлдэгдлээр байгаа бөгөөд хамгаалах хэрэгслийн болон ариутгал халдваргүйтгэлийн бараа материалын үлдэгдэлд үлдсэнтэй холбоотой байна.

Хүснэгт № 5. Бараа материалын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засаг даргын Тамгын газар	50117.9	20215.8	271.0	0.6
ИТХ	969.0	1240.0	-29902.1	9.2
Ерөнхий боловсролын сургууль	71433.7	88055.9	16622.1	40.3
Хүүхдийн цэцэрлэг	30774.2	51392.4	20618.2	23.5
Соёлын төв	11496.1	12852.1	1356.0	5.9
Орон нутгийн хөгжлийн сан	45000.0	45000.0	0	20.6
НИЙТ ДҮН	209790.9	218756.1	8965.2	100.0

Эх сурвалж: Баянцагаан сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд нийт нэмэгдсэн 213295.4 мянган төгрөгийн бараа материалын 208277.2 мянган төгрөг нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан, 3998.3 төгрөгийн материал шилжүүлэн авсан. бусад хангамжийн материалд 1020.0 мянган төгрөгийн мал амьтад бүртгэснийг шилжүүлж мал амьтад бүртгэсэнтэй холбоотой байна.

Тайлант онд ИТХ 694.0 мянга, Засаг даргын Тамгын газар 45.6 мянга, ерөнхий боловсролын сургууль 3258.6 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус шилжүүлэн авсан байна.

Хүснэгт № 6. Бараа материалын орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/

Нэмэгдсэн	213,295.4	Хасагдсан	1,535,922.5
Худалдан авсан	208,277.2	Худалдсан, зарцуулсан	157798.6
Шилжүүлэн авсан	3998.3	Шилжүүлсэн	4600.0
бусад	1020.0	бусад	1020.0

Эх сурвалж: Баянцагаан сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 5,669,884.1 мянга, эцсийн үлдэгдэл 5940067.7 мянган төгрөг болж, 270,183.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
БИЕТ ХӨРӨНГӨ	5,609,644.1	5,880,727.7	271,083.6
Барилга, байгууламж, орон сууц	4,588,966.7	4,698,757.3	109,790.60
Авто-тээврийн хэрэгсэл	178,184.2	155,334.2	(22,850.00)
Машин тоног төхөөрөмж (компьютер)	398,936.3	442,223.1	43,286.77
Тавилга, аж ахуйн эд хогшил	204,575.3	209,378.9	4,803.64
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	106.3	106.3	-
Бусад үндсэн хөрөнгө	210,819.0	342,135.9	131,316.94
Ном	28,056.1	32,791.8	4,735.67
БИЕТ БУС ХӨРӨНГӨ	60,240.0	59340.0	(900.0)
Программ хангамж	2,130.0	1,430.0	(700.00)
Бусад биет бус хөрөнгө	58,110.0	57,910.0	(200.00)
НИЙТ ДҮН	5,669,884.1	5,940,067.7	270,183.6

Эх сурвалж: Баянцагаан сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

- Тайлант онд 270183.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд үүний 96.8 хувь буюу 261536.4 мянган төгрөгийг хөрөнгийн үнэ төлбөргүй шилжүүлэн авсан нь голлох нөлөө үзүүлж байна. Үүнд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр ЗДТГазар 90190.6 мянга, аймгийн ИТХ-ын 2020 оны 121 тоот тогтоолыг үндэслэн 15 кв 160 дэд станц, ЦДАШ 103816.9 мянга, төсөл хөтөлбөр болон БСШУ-ны яамны хөрөнгө оруулалтаар ерөнхий боловсролын сургууль 7152.2 мянга, цэцэрлэг 9248.5 мянга, соёлын төв 1000.0 мянган төгрөгийг тус тус орлого авсан байна.

Хүснэгт № 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
ИТХ	144,364.1	146,564.1	2,200.0
ЗДТГ	2,513,167.1	2,739,852.5	226,685.4
Сургууль	2,049,592.5	2,075,645.0	26,052.5
Цэцэрлэг	401,207.3	414,977.7	13,770.4
Соёлын төв	561,553.0	563,028.3	1,475.3
НИЙТ ДҮН	5,669,884.1	5,940,067.7	270,183.6

Эх сурвалж: Баянцагаан сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тухайн онд 37446.2 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан авсан, 101.3 мянган төгрөгийн хөрөнгө хандиваар, 261536.1 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлсэн авсан байна.

Мөн аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2020.01.21-ны өдрийн 03 тоот тогтоолоор 28000.0 мянган төгрөгийн үнэтэй Ланд 80 маркийн автомашин, ерөнхий боловсролын сургуулийн 500.0 мянган төгрөгийн өртөгтэй архив болон сургалтын программ, Хүүхдийн цэцэрлэгийн 200.0 мянган төгрөгийн өртөгтэй архивын программыг тус тус акталсан байна.

Хүснэгт № 9. Үндсэн хөрөнгийн орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/

Нэмэгдсэн	299083.6	Хасагдсан	28900.0
Худалдан авсан	37446.2	Худалдсан	
Хандиваар	101.3	Акталсан	28900.0
Шилжүүлэн авсан	261536.1	Бусад	

Эх сурвалж: Баянцагаан сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 16946.4 мянга, эцсийн үлдэгдэл 10077.2 мянган төгрөг болж 6869.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 10. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР ДҮН				
Ажилчидтай холбогдсон өглөг	538.1	10,077.2	9,539.1	100
Байгууллагад төлөх өглөг	16,408.3	-	(16,408.3)	
Дүн	16946.4	10077.2	(6869.2)	100

Эх сурвалж: Баянцагаан сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөр нь 10077.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд энэ нь ерөнхий боловсролын сургуулийн НДШ-ийн өглөг байгаа ба тус байгууллага нь санхүүжилт байхад тайлант онд гүйлгээ хийгээгүй байснаас үүссэн байна.

Хүснэгт № 11. Нийт өр төлбөрийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засаг даргын Тамгын газар	538.1	-	(538.1)	
Ерөнхий боловсролын сургууль	16408.3	10077.2	(6,331.1)	100.0
НИЙТ ДҮН	13,172.08	3,737.93	(6,869.2)	100.00

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 33764455.2 мянга, эцсийн үлдэгдэл 37445630.4 мянган төгрөг болж, 3681175.2 мянган төгрөгөөр төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 12. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,168,230.9	2,168,230.9	-	

Өмч: - төрийн	2,168,230.9	2,168,230.9		47.8
Хуримтлагдсан үр дүн	556,100.4	669,193.4	113,093.0	14.8
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,694,940.2	1,694,940.2		37.4
Дүн	4,419,271.5	4,532,364.5	113,093.0	100

Эх сурвалж: Баянцагаан сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 4532364.5 мянган төгрөг болж 113093.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн хуримтлагдсан үр дүнгийн 113093.0 мянган төгрөгийн өссөнтэй холбоотой байна.

3.5.10 Орлогын данс

Сумын ИТХ-ын 2019.12.18-ний өдрийн хуралдаанаар 15/18 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 151340.0 мянга, хүү торгуулийн орлогыг 3000.0 мянга, нийт 154340.0 мянган төгрөгөөр анх баталсан ба 2020.09.29-ны өдрийн 17/04 дугаар тогтоолоор сумын төсөвт төвлөрүүлэх орлогыг 21000.0 мянган төгрөгөөр хасаж тодотгон татварын орлогыг 130340,0 мянга, хүү торгуулийн орлогыг 3000.0 мянган төгрөгөөр баталжээ.

Хүснэгт №13. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1.Татварын орлого	130340.0	131575.8	1235.8	100.9
1.1.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8.1.1-д заасан орлогод ногдох албан татвараас бусад хувь хүний орлогын албан татвар	4000.0	26487.4	22,487.4	662.2
1.2. Бууны албан татвар	4200.0	2355.0	(1,316.5)	56.1
1.3. Улсын тэмдэгтийн хураамж	10700.0	2351.7	(8,348.3)	38.9
1.4.Хадгаламжийн хүүгийн орлого	56000.0	54683.5	(1,316.5)	97.6
1.5.Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж	22000.0	21945.1	(54.9)	99.8
1.6.Газрын төлбөр	1440.0	560.5	(879.5)	38.9
1.7.Нохойны татвар	1000.0	110.0	(890.0)	11.0
1.8.Хог хаягдлын үйлчилгээний төлбөр	30000.0	21902.6	(8,097.4)	73.0
1.9. ТТАМАТөлбөр	1000.0	1180.0	180.0	118.0
2.Татварын бус орлого	3000.0	7057.5	4057.5	235.2
2.1.Хүү торгуулийн орлого	3000.0	7057.5	4057.5	235.2
Нийт дүн	133340.0	138633.3	5293.3	103.9

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 1235.8 мянга, хүү торгуулийн орлогыг 4057.5 мянга, нийт 5293.3 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Орлогын нэр төрлөөр авч үзвэл хувь хүний орлогын албан татвар, түгээмэл тархацтай ашигт малтмалын ашигласны төлбөрийн албан татвар давуулан биелүүлсэн ба бусад албан татварууд 11-99.8 хувийн биелэлттэй орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогод Засаг даргын Тамгын газар 1000.0 мянган төгрөгийн орлогоос 507.9 мянга, соёлын төв 3000.0 мянган төгрөгийн орлогоос 877.0 мянга, ерөнхий боловсролын сургууль 1000.0 мянган төгрөгийн орлогоос 377.1 мянган төгрөгийн орлогыг тус тус оруулсан байна.

Сум хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн төлөлтөөр тайлант онд 55000.0 мянган төгрөгийг оруулахаар баталснаас 84846.5 мянган төгрөгийн орлогыг оруулсан байна.

3.5.11 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71702, 71801, 71802, 71806, 72101 гэсэн кодтой 8 хөтөлбөрт зориулан 2510994.2 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 22873255.4 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас 2217519.5 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулсан бол 22592.6 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд буюу ОНХС-ийн хөрөнгөөс зарцуулсан байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Аймгийн СТСХ-ээс авсан судалгаагаар тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 5 төсвийн байгууллага 2162427.1 мянган төгрөгийн төсвийн төслийг бэлтгэж хүргүүлсэн ба 160741.9 мянган төгрөгийг нэмэгдүүлж баталсан байна.

Хүснэгт №14. Төсвийн төлөвлөлт байгууллагаар /мянган төгрөг/

Байгууллагын нэр	Төсвийн төсөл	Анх батлагдсан төсөв	Зөрүү
Ерөнхий боловсролын сургууль	1,155,156.5	1,286,671.4	(131,514.9)
Хүүхдийн цэцэрлэг	459,552.3	438,884.4	20,667.9
ИТХ	85,158.2	70,639.4	14,518.8
ЗДТГ	354,208.9	428,061.3	(73,852.4)
Соёлын төв	108,351.2	98,912.5	9,438.7
Төсөвт байгууллагын дүн	2162427.1	2323169.0	160741.9
Сум хөгжүүлэх сан		145,000.0	(145,000.0)
Орон нутгийн хөгжлийн сан		154,088.5	(154,088.5)
Нийт дүн	2,162,427.1	2,622,257.5	(459,830.4)

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2019.12.18-ний өдрийн 15/18 дугаар тогтоолоор анх баталсан 2676791.6 мянган төгрөгийг 2020.09.29-ний өдрийн 17/04 дугаар тогтоолоор 54534.1 мянган төгрөгөөр бууруулж баталсан бол тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зардлыг аймгийн Засаг даргын 2020.11.27-ний өдрийн А/770 дүгээр захирамжаар 7319.4 мянга, 2020.12.31-ний өдрийн А/850 дугаар захирамжаар 103943.9 мянган төгрөгөөр бууруулснаар сумын нийт төсөв 2510994.2 мянган төгрөг болжээ.

Нийт зардлын 1473574.2 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс, 154088.5 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 531606.3 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 133340.0 мянган төгрөгийг сумын орон нутгийн төсвөөс, 60000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 158385.2 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтийг бүрэн авч, орон нутгийн төсвөөс авах санхүүжилтийг 20889.9 мянган төгрөгөөр дутуу, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтийг 30850.3 мянган төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн ба улсын төсөвт 68098.7 мянга, орон нутгийн төсөвт 26887.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт №15. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөг/

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	Улсын төсөвт төвлөрүүлсэн	ОН төсөвт төвлөрүүлсэн
ИТХ	70639.4	67086.3	3553.1	95.0		3553.1
ЗДТГ	428061.3	392277.3	35784.0	91.6		16401.9
Соёлын төв	98912.5	90596.3	8316.2	91.6		4193.2
Сум хөгжүүлэх сан	145000.0	124727.9	20272.1	86.0		
ЕБС	1228665.0	1170525.1	58139.9	95.2	55596.4	1920.5
Хүүхдийн цэцэрлэг	385627.5	372306.5	13321.0	96.5	12502.3	818.7
Орон нутгийн хөгжлийн сан	154088.5	69806.0	84282.5	45.3		
Нийт дүн	2510994.2	2287325.2	223668.7	91.1	68098.7	26887.5

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2287325.2 мянган төгрөг буюу 91.1 хувьтай байгаа нь Засаг даргын Тамгын газрын зардлыг 35784.0 мянга, ерөнхий боловсролын сургуулиудын урсгал зардлыг 58139.9 мянга, орон нутгийн хөгжлийн сангийн зардлыг 84282.5 төгрөгөөр тус тус хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт 16. Баянцагаан сумын Засаг даргын төсвийн гүйцэтгэл, хөтөлбөрөөр /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,510,994.2	2,287,325.5	223,668.7	91.09
70105 ОН-ын өөрөө удирд ёсны байгуул	70,639.4	67,086.3	3,553.1	94.97
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	53,247.2	51,407.5	1,839.7	96.55
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	4,200.0	3,838.0	362.0	91.38
80825 Багийн ИНХ-ын дарны урамшуулал	13,192.2	11,840.8	1,351.4	89.76
70106 ОН-ын гүйцэтгэх засаглалын үди	428,061.3	392,277.3	35,784.0	91.64
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	289,495.5	268,408.8	21,086.7	92.72
80106 Баг, хорооны ҮАЗардал	76,402.7	73,448.1	2,954.6	96.13
80305 Биеийн тамирын уралдаан, тэмцэ	1,000.0	-	1,000.0	-
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	1,000.0	990.0	10.0	99.00
81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	17,563.1	17,555.0	8.1	99.95
81701 Байгаль орчныг хамгаалах, нөхө	12,600.0	7,600.0	5,000.0	60.32
82212 Хур хог хаягдал, орчны бохирдл	30,000.0	24,275.4	5,724.6	80.92
70503 Орон нутгийн зорилтот ХОруулал	154,088.5	69,806.0	84,282.5	45.30
80904 Нийгмийн зориулалттай барилга	154,088.5	69,806.0	84,282.5	45.30
71702 Соёл урлаг	98,912.5	90,596.3	8,316.2	91.59
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	94,670.7	89,626.3	5,044.4	94.67
80214 Уран бүтээл хийлгэх	3,941.8	870.0	3,071.8	22.07
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	300.0	100.0	200.0	33.33
71801 Сургуулийн өмнөх боловсрол	385,627.5	372,306.5	13,321.0	96.55
80109 ТЗШ-ийн бга-уудын тогтмол зардал	17,379.5	16,560.8	818.7	95.29
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	180.8	180.6	0.2	99.89
81807 Цэцэрлэгийн хүүхдийн хоол	30,419.3	27,158.2	3,261.1	89.28
81834 Боловсролын стандарт, сургалты	297,927.1	289,231.7	8,695.4	97.08
81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	39,720.8	39,175.2	545.6	98.63
71802 Ерөнхий боловсрол	1,217,784.0	1,162,104.1	55,679.9	95.43
80109 ТЗШ-ийн бга-уудын тогтмол зардал	122,338.8	120,418.2	1,920.6	98.43
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	1,639.5	1,639.5	-	100.00
81801 үдийн цай хөтөлбөр	20,727.0	15,844.5	4,882.5	76.44
81806 Дотуур байрны үйлчилгээ	124,672.3	105,380.2	19,292.1	84.53
81834 Боловсролын стандарт, сургалты	724,994.6	707,591.0	17,403.6	97.60
81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	223,411.8	211,230.6	12,181.2	94.55
71806 Насан түршын болон албан бус б	10,881.0	8,421.1	2,459.9	77.39
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	10,881.0	8,421.1	2,459.9	77.39
72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	145,000.0	124,727.9	20,272.1	86.02
82611 Жижиг дунд үйлдвэрийг дэмжих	145,000.0	124,727.9	20,272.1	86.02

Эх сурвалж: "Баянцагаан сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан"

1.Цалин НДШ-ийн зардал

Цалин хөлс, нэмэгдэл урамшил 1430553.5 мянган төгрөг төлөвлөснөөс 1388644.4 мянган төгрөгийн зардал гүйцэтгэлээр гарч 41909.1 мянган төгрөг хэмнэгджээ. Хэмнэлтийн шалтгаан нь:

- Ковид-19 цар тахалтай холбоотой бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж сургууль, цэцэрлэгүүд ажиллаагүйгээс Сургууль, Цэцэрлэгийн албан хаагчдын цалин хэмнэгдсэн

- ЗДТГ-ын ажиллах ёстой бүтцээс 3 албан хаагчийн сул орон тооны цалин хэмнэгдсэн. Энэ нь тухайн 3 албан тушаалд мэргэжлийн шаардлага хангах боловсон хүчин байхгүй, төрийн албаны шалгалтад тэнцээгүй, Ковид-19 цар тахалтай холбоотой бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж төрийн албаны ерөнхий шалгалт зарлагдахгүй хойшилсон зэрэг шалтгаанаар ХАА-н тасгийн 2 мэргэжилтэн, Санхүүгийн албаны төсөв төрийн сангийн мэргэжилтэн зэрэг албан тушаалуудыг хавсарч ажилласан учир цалингийн зардал хэмнэгдсэн.

- НДШ-ийн зардал 194319,8 мянган төгрөг төлөвлөснөөс 176689,5 мянган төгрөгийн НДШ-ийн зардал гүйцэтгэлээр гарч 17630,3 мянган төгрөг хэмнэгдсэн. Энэ нь дээрх шалтгаануудаас цалингийн зардал хэмнэгдсэнээс НДШ-ийн зардал хэмнэгдсэн.

2. Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал

- Байр ашиглалттай холбоотой зардал нийтдээ 195064.0 мянган төгрөг төлөвлөснөөс 189215.9 мянган төгрөгийн зардал гүйцэтгэлээр гарч 5848.1 мянган төгрөг хэмнэгджээ. Хэмнэлтийн шалтгаан нь Ковид-19 цар тахалтай холбоотой бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбоотой Сургууль, Цэцэрлэг, Соёлын төв зэрэг байгууллагууд тодорхой хугацаагаар үйл ажиллагаа явуулахгүй байсны улмаас гэрэл цахилгаан, түлш халаалт зэрэг зардлууд бага хэмжээгээр хэмнэгдсэн байна.

3. Хангамж бараа материалын зардал

Хангамж, бараа материалын зардал нийтдээ 65884.9 мянган төгрөг төлөвлөснөөс 61202.4 мянган төгрөгийн зардал гүйцэтгэлээр гарч 4682.5 мянган төгрөг хэмнэгджээ. Энэ бүлгийн зардлаас тээвэр шатахууны зардал, ном хэвлэлийн зардал хэмнэгдсэн байна. Хэмнэлтийн шалтгаан нь Ковид-19 цар тахалтай холбоотой бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбоотой сургалт семинарыг хорьсонтой холбоотой ЗДТГ-ын тээвэр шатахууны зардал, 2021 онд болох сумын ойд зориулж түүхэн ном хийлгэхээр төлөвлөсөн байсан зардал гараагүй учир ЗДТГ-ын ном хэвлэлийн зардал хэмнэгдсэн.

4. Нормативт зардал

Нормативт зардал нийтдээ 101294.8 мянган төгрөг төлөвлөснөөс 79223.9 мянган төгрөгийн зардал гүйцэтгэлээр гарч 22070.9 мянган төгрөг хэмнэгджээ. Хэмнэлтийн шалтгаан нь Ковид-19 цар тахалтай холбоотой бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж сургууль, цэцэрлэгүүд ажиллаагүйгээс хүүхдийн хоолны зардал хэмнэгдсэн байна.

5. Томилолт, зочны зардал

Нормативт зардал нийтдээ 13225.3 мянган төгрөг төлөвлөснөөс 8541.0 мянган төгрөгийн зардал гүйцэтгэлээр гарч 4684.3 мянган төгрөг хэмнэгджээ. Хэмнэлтийн шалтгаан нь Ковид-19 цар тахалтай холбоотой бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбоотой сургалт семинарыг хорьсонтой холбоотой ЗДТГ, ИТХ-ын томилолтын зардал хэмнэгдсэн.

6. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хураамжийн зардал нийтдээ 194232.4 мянган төгрөг төлөвлөснөөс 163682.2 мянган төгрөгийн зардал гүйцэтгэлээр гарч 30550.2 мянган төгрөг хэмнэгджээ. Хэмнэгдсэн гол зардал бол Сум хөгжүүлэх сангийн зээлийг төлөвлөсөн хэмжээнээс бага олгосонтой холбоотой. Энэ нь зээлийн эргэн төлөлт оны эцэст 12-р сард байсан учраас Сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах зөвлөл дахин хуралдаж зээл олгож амжаагүй.

7. Бараа үйлчилгээний бусад зардал

Бараа үйлчилгээний бусад зардал нийтдээ 66609.5 мянган төгрөг төлөвлөснөөс 60565.3 мянган төгрөгийн зардал гүйцэтгэлээр гарч 6044.2 мянган төгрөг хэмнэгджээ. Хэмнэгдсэн зардал нь ЗДТГ-ын байгаль хамгаалах зардал 12600.0 мянган төгрөгөөр

төлөвлөсөн байсныг Сангийн яамнаас төсвийн хэмнэлтийн горимд шилжсэнтэй уялдуулан 6600.0 мянган төгрөгийн зарцуулалтын эрхийг нээж үлдэх 6000.0 мянган төгрөгийн зарцуулалтын эрхийг нээгээгүй учир зардал гараагүй хэмнэгдсэн байна. Мөн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын зардал өмнөх оноос буурснаас шалтгаалжээ.

8.Бусад урсгал шилжүүлэг

Энэ бүлгийн зардлаас Сургуулийн үдийн цайны зардал хэмнэгдсэн. Жилийн төсөв 20727,0 мянган төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 15844.5 мянган төгрөгийн зардал гарч 4882.5 мянган төгрөгийн зардал хэмнэгдсэн. Ковид-19 цар тахалтай холбоотой бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж сургууль, цэцэрлэгүүд ажиллаагүйгээс Сургуулийн үдийн цайны зардал хэмнэгдсэн

9.Хөрөнгийн зардал.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний зардал 154088.5 мянган төгрөгөөр төлөвлөснөөс 69806.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын зардал гарч 84282.5 мянган төгрөгийн зардал хэмнэгдсэн. Сангийн яамнаас орон нутгийн хөгжлийн санхүүжилт дутуу ирсэн, мөн оны эцэс рүү санхүүжилт ирснээс төсөл арга хэмжээг санхүүжүүлэх боломжгүй болсон зэрэг шалтгаануудаас хэмнэгдсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 3 байгууллага 109357.4 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 1 байгууллага 4515.4 мянга, нийт 113872.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжид 75763.8 мянга, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгт 9391.5 мянга, хашаа байшин, орон сууцны хөнгөлөлтөд 5000.0 мянга, сурах бичгийн үнэ 3873.6 мянга, тэргүүний сумын шагнал 12000.0 мянга, хамтарсан багийн санхүүжилт 2000.0 мянга, барьцаа хөрөнгө 1550.0 мянга, хүн ам орон сууцны тооллогын зардалд 965.4 мянга нийт 110544.3 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 3328.5 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Үзүүлэлт	ЗДТГ	ИТХ	ЕБС	Цэцэрлэг	ЭМТ	НИЙТ
НИЙТ ОРЛОГО	16515.4	--	92357.4	-	-	109357.4
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	5000.0	-	-	-	-
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12000.0	-	92357.4	-	-	-
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4515.4	-	-	-	-	-
НИЙТ ЗАРЛАГА	16515.4	5000.0	89028.9	-	-	110544.3
Бараа, ажил үйлчилгээний зардал	-	5000.0	3873.6	-	-	-
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	-	75763.8	-	-	-

Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	-	9391.5	-	-
Төсөвт төвлөрүүлсэн	-	-	3328.5	-	-

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 155 мэдээллээс 145 мэдээллийг хугацаанд нь, 10 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Хүснэгт 17. Шилэн дансны мэдээлэл

д/д	хугацаа	төрөл	удаа	хугацаанд нь мэдээлсэн	хугацаа хоцроосон	хоцроосон мэдээлэл
1	Бүтэн жил	12	12	7	5	Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө гүйцэтгэл, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлт, засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө гүйцэтгэл, худалдан авах ажиллгааны төлөвлөгөө, хөрөнгийн зардал, хөрөнгийн оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессийн зүйлийн жагсаалт, гүйцэтгэл мэдээлэлүүдийг тус тус хоцроосон.
2	Хагас жил	3	3	3	-	
3	Улирал бүр	2	8	8		
4	Сар бүр	5	60	59	1	Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл 10 сард хоцроосон.
5	Тухай бүр	6	72	68	4	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт 4 сар, таван сая төгрөгөөс дээш үнийн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ 5 сар, 6 сар, 7 саруудад мэдээллийг хоцроож байршуулсан байна.
НИЙТ		30	155	145	10	

Эх сурвалж. Баянцагаан сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудас

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байр 1 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна. Зөвлөмжийн биелэлтийг сумын засаг даргын 2020.06.09-ний өдрийн 1/132 тоот албан бичгээр ирүүлж биелэлтийг тооцсон байна.

Хүснэгт 18 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	-	1	-			100.0
Нийт	1	-	1	-			100.0

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 5 төсвийн байгууллага, 2 тусгайн сангийн нийт 7 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс бүх байгууллага аудитад хамрагдсан ба 3 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж 3 байгууллагын санхүүгийн тайланд түүвэрт хамруулж 1 байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд дүгнэлт гаргасан 3 байгууллагад “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяаны төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 98001.9 мянган төгрөгийн 10 алдаа, зөрчил илэрснээс 20000.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 23292.0 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 54710.0 мянган төгрөгийн зөрчилд менежментийн захидлаар удирдлагад зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 8 заалт бүхий зөвлөмж өгч, 1920.0 мянган төгрөгийн 1 алдааг санхүүгийн тайланд залруулжээ. /Хавсралт 2./

Аудитаар нийт 81000.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 81000.0 мянган төгрөгийн алдааг залруулж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө. /Хавсралт 1./

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд сум хөгжүүлэх сангийн урд оны үлдэгдлээс санхүүжих эх үүсвэрийг 81000.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн байна.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх асуудал байхгүй

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

4.1 УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

4.1.1. **Илрүүлэлт:** Төсөвт байгууллагын болон сангийн нягтлан бодогч нар Сангийн яамны Э-тайланд санхүүгийн тайлангийн хөрөнгө материал, орлого, зарлагын төрлийг зөрүүтэй тайлагнасан, харьяа төсвийн шууд захирагчийн байгууллагууд нь хөрөнгө материалыг аваагүй байхад тодотгол хийж хөрөнгө бэлтгэхээр ААНБ-д мөнгийг шилжүүлж авлага үүсгэсэн, анхан шатны баримтын бүрдэлгүй гүйлгээ хийсэн зөрчил санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн байхад сумын санхүүгийн албаны дарга хяналт тавьж ажиллаагүй байна.

Энэ нь Үнэн зөв байдал, Хэмжилт, Оршин байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 55 дугаар тушаалыг тус тус зөрчсөн байна.

4.1.2. **Эрсдэл:** Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн материаллаг хэмжээний алдаа зөрчлийн дүн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хүлээн зөвшөөрөгдөх материаллаг байдлаас хэтэрсэн байх.

4.1.3 **Өгсөн зөвлөмж:** Сумын төсөвт байгууллагуудын нягтлан бодох бүртгэл, анхан шатны баримтын бүрдэл, санхүүгийн тайлангийн үнэн зөв гаргасан байдал, аудитлагдсан санхүүгийн тайланг Сангийн яамны Э-тайланд орлого, зарлагыг данс бүрээр тайлагнаж байгаад тавих Төрийн сангийн дотоод хяналтыг сайжруулах.

4.1.4 **Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн.

4.2. УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

4.2.2 **Илрүүлэлт:**

Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 155 мэдээллээс 145 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 10 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх зарчмыг баримтална" гэснийг зөрчсөн байна.

4.2.2 **Эрсдэл:** Төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоо бүрдүүлэхгүй байх.

4.2.3 **Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь бүрэн байршуулах.

4.2.4 **Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 06 дугаар сарын 25-ний дотор нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:

АУДИТОР

Н.БҮНЧИНСҮРЭН 2021.03.25

Анхан шатанд хянасан:
АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ 2021.03.25

Хоёр дахь шатанд хянасан:
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ 2021.03.25

5. Хавсралт 1.: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо 2020	Аудитын нэр:	Баянцагаан сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит	Аудитын код:		
			БНА-2021/16/СТА-ТТ3		
Шалгагдсан байгууллагын нэр:		Баянцагаан сумын Засаг дарга	Мянган төгрөг		
№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Санхүүгийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд сум хөгжүүлэх сангийн урд оны үлдэгдлээс санхүүжих эх үүсвэрийг 81000.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн байна.	81000.0	Санхүүгийн тайланд залруулсан.	Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга	Н.Гансүх Д.Аюуш
2	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүйгээс 14 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.	-	Зөвлөмж өгсөн.	Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга	Н.Гансүх Д.Аюуш
3	Төсөвт байгууллага, сангийн нягтлан бодогч нар Сангийн яамны Э-тайланд санхүүгийн тайланд хөрөнгө материал, орлого, зарлагын төрлийг зөрүүтэй тайлагнасан, харьяа төсвийн шууд захирагчийн байгууллагууд нь хөрөнгө материалыг аваагүй байхад тодотгол хийж хөрөнгө бэлтгэхээр ААНБ-д мөнгийг шилжүүлж авлага үүсгэсэн, анхан шатны баримтын бүрдэлгүй гүйлгээ хийсэн зөрчил санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн байхад сумын санхүүгийн албаны дарга хяналт тавьж ажиллаагүй байна.	-	Зөвлөмж өгсөн.	Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга	Н.Гансүх Д.Аюуш
ДҮН		81000.0			

оОо

6. Хавсралт 2.: Харьяа ТШЗ-ийн байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт /мянган төгрөгөөр/

№	Аудитаар илэрүүлсэн алдаа зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Алдаа зөрчлийн шийдвэрлэлт	Алдаа зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтан	
				Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5
Засаг даргын Тамгын газар		54,974.70			
1	Баянцагаан сумын ЗДТГ-т бүртгэлтэй 73-24 БНА улсын дугаартай TLC 200 автомашинд 7336.2 мянган төгрөгийн засвар үйлчилгээ, 813.7 мянган төгрөгийн зогсоолын төлбөр төлсөн байна. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд 59800.0 мянган төгрөгөөр хуучин ашиглаж байсан автомашиныг худалдан авч 3 жилийн дотор их засварт орж төсөвт их хэмжээний зардал үүсгэж байна.	8,150.0	Зөвлөмж өгсөн	Дарга, нягтлан бодогч	М.Чинбат, Г.Түмэнболд
2	Тайлант онд Сум дундын ойн ангиас ирсэн 23292.0 мянган төгрөгийн өвс тэжээлийг 11,12 сард хүлээн авч, мөнгийг бүрэн шилжүүлсэн боловч тус өвсийг бараа материалын дансанд орлого зарлагаар бүртгээгүй байна.	23,292.0	Албан шаардлага өгсөн	Дарга, нягтлан бодогч	М.Чинбат, Г.Түмэнболд
3	Жилийн эцсийн тооллогоор 23532.7 мянган төгрөгийн хорогдсон малыг мал эмнэлгийн дүгнэлт гараагүй, байгууллагын даргын тушаал шийдвэргүй данснаас хассан, ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга, хэмжээг орлого авахдаа сумын Засаг даргын захирамжийг үндэслэн хөрөнгө орлого авсан.	23,532.7	Зөвлөмж өгсөн	Дарга, нягтлан бодогч	М.Чинбат, Г.Түмэнболд
4	Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 16 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан		Зөвлөмж өгсөн	Дарга, нягтлан бодогч	М.Чинбат, Г.Түмэнболд
Ерөнхий боловсролын сургууль		23,027.20			
5	Санко Маркетинг Монголиа ХХК-ийн нийлүүлэгдэх 9950,0 мянган төгрөгийн үнэ бүхий ухаалаг самбар нь биетээр авлага үүсгэсэн байна.	9,950.0	Зөвлөмж өгсөн	Захирал, Нягтлан бодогч	С.Нандинцэцэг Г.Наранчимэг
6	12-р сард ажил олгогчоос төлөх шимтгэлийн 10077.2 мянган төгрөгийг шилжүүлээгүй байна.	10,077.2	Зөвлөмж өгсөн	Захирал, Нягтлан бодогч	С.Нандинцэцэг Г.Наранчимэг
7	Хичээл практикийн зардлаас 6 настны ширээ 3000,0 мянган төгрөгөөр бэлтгэсэн байна.	3,000.00	Зөвлөмж өгсөн	Захирал, Нягтлан бодогч	С.Нандинцэцэг Г.Наранчимэг
8	Шилэн дансны сайтад 151 мэдээ мэдээлхээс мэдээллийг бүрэн байршуулсан бөгөөд үүнээс 89360,7 мянган төгрөгийн 21 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.		Зөвлөмж өгсөн	Захирал, Нягтлан бодогч	С.Нандинцэцэг Г.Наранчимэг
Орон нутгийн хөгжлийн сан		20000.0			
9	Баянцагаан сумын ИТХ-ын 2019 оны 15/18-р тогтоолоор сумын 60.0 сая төгрөгийн өртөгтэй Мал эмнэлгийн барилга барихаар төлөвлөсөн үүнээс 20.0 сая төгрөгийг сумын ОНХС-гаас олгохоор баталж "Баялаг Өлзий" ХХК-тай 2020.12.18-ны өдөр барилгын ажил гүйцэтгэх шууд гэрээ байгуулан мөнгийг бүрэн олгосон бөгөөд тус барилга нь мэргэжлийн байгууллагын зураг төсөв хийгдээгүй, ажил эхлээгүй байна.	20000.0	Төлбөрийн акт тогтоосон	Засаг дарга, Нягтлан бодогч	Н.Гансүх Т.Одмаа
Хүүхдийн цэцэрлэг		1920.0			
10	Байршуулбал зохих 149 мэдээллээс сар бүр байршуулах 2 төрлийн 5, тухай бүр байршуулах 6 төрлийн 8, бүтэн жилээр байршуулах 3 төрлийн 3 мэдээлэл, нийт 9 төрлийн 16 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн			Цэцэрлэгийн эрхлэгч, нягтлан бодогч	Ц.Өлзийсайхан Г.Наранчимэг
11	Төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 1920.0 мянган төгрөгийн үнэтэй 40 м худдаасыг үндсэн хөрөнгөд орлогод авсан нь УСНББОУС-17-г зөрчсөн.	1920.0	Санхүүгийн тайланд залруулсан	Цэцэрлэгийн эрхлэгч, нягтлан бодогч	Ц.Өлзийсайхан Г.Наранчимэг
		99,921.9			

oOo